



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар**

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ААГ-ын Тэргүүлэх аудитор
О.Ганболд
Утас: 70383793

Аудитын менежер:
Г.Эрдэнэчимэг
Утас: 70384044

Ахлах аудитор:
Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114

Аудитор:
Л.Магсаржалам
Утас: 99039903

**ТАБ-ын хаяг: АЗДТГ
Байршил: А корпус 3
давхар
Цахим хуудас:
www.audit.mn**

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн
тайлан

Хавсралт 5: Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн
тайлан

Хавсралт 6: Нэгтгэсэн нэмэлт төсвийн
гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:
Г.Эрдэнэчимэг

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ...	5
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	10
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	10
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	10
2.9.1	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	10
2.9.2	Мөнгөн хөрөнгө дансны талаар.....	11
2.9.3	Авлага дансны талаар.....	11
2.9.4	Бараа материал дансны талаар	12
2.9.5	Үндсэн хөрөнгийн талаар.....	13
2.9.6	Урт болон богино хугацаат өр төлбөрийн талаар	14
2.9.7	Эзэмшигчийн өмчийн талаар.....	15
2.9.8	Хуримтлагдсан үр дүнгийн талаар	15
2.9.9	Дахин үнэлгээний нөөцийн талаар.....	15
2.9.10	Орлого дансны талаар	15
2.9.11	Зардал дансны талаар.....	16
2.9.12	Хөрөнгө оруулалтын талаар.....	16
2.9.13	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар.....	17
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	17
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	17
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	18
2.13	Өмнөх зөвлөмжийн талаар.....	19
2.14	. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	19
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	19
3	Менежментийн захидал	20
3.1	Санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь алдаа, зөрчлийн талаар.....	21
3.2	Төсвийн хэмнэлтийн горимын талаар.....	22
3.3	Авлага дансны талаар	22

3.4	Бараа, материал дансны талаар.....	23
3.5	Захиалагчийн хяналтын зардлын талаар.....	23
3.6	Үндсэн хөрөнгө дансны талаар.....	24
3.7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар	25
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	25
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	25
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	26
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	27
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	28
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	29
4.6	Аудит хийсэн НЭМЭЛТ ТӨСВИЙН гүйцэтгэлийн тайлан	32

1 Аудитын гэрчилгээ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.04.20 № 06/509
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Л.ГАНБОЛД
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгад санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан, нэгтгэсэн үр дүнгийн тайлан, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт/-ийн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.ГАНБОЛД



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Л.Ганболд таньд танилцуулж байна.

Энэхүү тайланд санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэж хүргүүлэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурьдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 01-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 20-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитор Л.Магсаржалам нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Засаг дарга 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн СТСХ-ийн даргын 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 8/613 тоот албан бичгээр Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36 “.....төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1.17 “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2 “төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн зорилгоор хяналтад байгаа нийт 301 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Үүнд:

№	Үзүүлэлт	Тоо
1	Төсвийн шууд захирагч	182
2	Орон нутгийн өмчит ХХК	42
3	Төсвийн төвлөрүүлэн захирагч	24
4	Төсвийн ерөнхийлөн захирагч	1
5	Төсөл сан	52
6	Нийт	301

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн зорилгоор хяналтад байдаг 301 байгууллагаас 180 байгууллагад бие даасан дүгнэлт өгч бусад байгууллагуудын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан аудит хийсэн.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн

тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна аймгийн Засаг даргын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 18 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд баримталж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2017 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавруудтай нийцэхгүй байна. Иймд дараах асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалын өөрчлөлттэй холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой өөрчлөлтийн асуудал
- Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэл, заавар, аргачлал, санхүүгийн тайлан гаргах зааварт өөрчлөгдсөн
- Анхан шатны баримт маягтын өөрчлөлттэй холбоотой асуудал байна.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” программ хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь Монгол улсын Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2014 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн А/69 тоот захирамжаар үүсгэн байгуулагдсан ба Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан дотоод аудитын дүрэм болон Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн хяналт шалгалтын стандартыг баримтлан үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Б/05 тоот захирамжаар баталсан 9 орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна. Тус алба нь 2017 онд 108 байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлж, 147,7 сая төгрөгийн акт тогтоож, 18 албан шаардлага хүргүүлэн, илэрсэн зөрчилд 1560 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна. Гэвч Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас хэрэгжүүлсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил нэмэгдэж, 1248,0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цаашид хүрсэн түвшингээ ахиулах, дотоод хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгох, аль болох мэрэгжлийн хүнээр бүрдүүлэх, дотоод хяналтыг оновчтой хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч 26 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг зориулалтаар нь баталгаажуулжээ.

Аймгийн ИТХ-ын 2016.12.05-ны 03 тоот тогтоолоор 2017 оны төсвийг баталсан ба төсвийн жилийн явцад 2 удаа “Төсвийн тухай” хуулийн 34 дүгээр 34.2.1 заалтыг үндэслэн тодотгол хийсэн байна. Үүнд:

1. ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд “Монгол улсын 2017 оны төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсантай холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор:
2. “Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль УИХ-аар 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсантай холбогдуулан 2017 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны 05 тоот тогтоолоор тус тус тодотгож баталсан байна.

Төсвийн орлогын талаар: Хөвсгөл аймгийн 2017 оны төсвийн нийт орлогод 90641,1 сая төгрөгийн орлого орох төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 91943,8 сая төгрөг орж төсвийн орлогын гүйцэтгэл 101,4% байна.

Хүснэгтээр харуулбал: /сая.төг/

Эх үүсвэрийн нэр төрөл	2017 он		Зөрүү
	төлөв	гүйц	
Улсын төсвөөс санхүүжих	58251,8	58218,8	33,0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	29667,8	31520,2	1852,4
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	604,1	558,9	-45,2
Урьд оны үлдэгдлээс	3450,1	0	-3450,1
Эргэж төлөгдөх зээл	2117,5	1426,7	690,8

Нийт дүн	94091,2	91724,6	-2366,6	2017 оны аймгийн төсвийн орлогын 63,5%-ийг улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгээр, 34,4%-ийг аймгийн орон нутгийн төсвөөр бүрдүүлсэн байна.
----------	---------	---------	---------	---

Төсвийн орлогын төлөвлөгөөг Арбулаг сум 2,1%, Баянзүрх 1,4%, Бүрэнтогтох 4,8%, Түнэл 1,5%, Улаан-уул 0,8%, Ханх 0,4%, Цагаан-үүр 4,4%, Чандмань-Өндөр 2,4%, Эрдэнэбулган 1,5%-иар тус тус тасалсан байна. Орлого тасалсан үндсэн шалтгаан нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой байна. Тухайлбал: 2017 онд аймгийн хэмжээнд 2117,5 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төвлөрүүлэхээр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 1426,7 сая төгрөг төвлөрсөн ба 67,3%-ийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн зардлын талаар: 2017 онд аймгийн төсвийн зарлага 94091.2 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 91270.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2820,5 сая төгрөгийн зардал хэмнэсэн мэт харагдаж байгаа сум хөгжүүлэх сангийн зээл олголт нөлөөлж байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг бүтцээр харуулбал:

	/сая,төг/			
	төлөв	гүйц	Зөрүү	%
Урсгал зардал	87420.1	86434.8	985,3	99
Хөрөнгийн зардал	4214,2	3824,4	389,8	90,8
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	2456,9	1011,5	1445,4	41,2
Нийт	94091.2	91270.7	2820,5	97,2



Нийт зардлын 95%-ийг урсгал зардал, 4%-ийг хөрөнгийн зардал, 1%-ийг эргэж төлөгдөх зээлийг хассан цэвэр дүн эзэлж байна. Төсвийн зардлыг хэтрүүлсэн сум болон төсөвт байгууллага байхгүй байна. Сумдын төсвийн зардлын гүйцэтгэл 94-100%-тай байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлд дараах зүйл нөлөөлсөн байна.

1. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор зарим сумдууд зээл олгоогүй байна.
2. Аймгийн төсвийн тухайд нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн зардал 469,8 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн нь нөлөөлж байна.
3. Хөрөнгийн зардал хэмнэгдсэн байна. /Дуусаагүй ажлын үлдэгдлийг санхүүжүүлээгүй байна./

Төсвийн гүйцэтгэлийг сайдын багцаар нь авч үзвэл дараах байдалтай байна.

	/сая,төг/		
Үзүүлэлт	Төлөв	Гүйцэт	зөрүү
Аймгийн Засаг дарга	37849.7	35055.9	2793,8
БХБСайд	249,8	249,3	0,5
БСШУСС	49435,6	49410,4	25,2
ХНХСайд	280,3	280,1	0,2
Эрүүл мэндийн сайд	6275,8	6 275,0	0,8
Нийт дүн	94091.2	91270.7	97,2

Аймгийн 2017 оны нийт төсвийн 42,7% ийг орон нутгийн төсөв, 57,3%-ийг тусгай шилжүүлэгийн байгууллагын төсөв эзэлж байна. Сайдын багцаар нь харвал аймгийн Засаг дарга 42,6%, БСШУССайд 50,4%, Эрүүл мэндийн сайдын багц 6,4%,

ХНХСайд 0,3%, БХБСайд 0,3%-ийг тус тус эзэлж байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг бүлгийн дүнгээр нь авч үзвэл дараах байдалтай байна.

Үзүүлэлт	/сая,төг/			
	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41389,6	41370,9	18,7	99,95
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4566	4559,9	6,1	99,87
Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	6810,5	6800,7	9,8	99,86
Хангамж, бараа материалын зардал	1916,5	1904,8	11,7	99,39
Нормативт зардал	3846,7	3844,4	2,5	99,94
Эд хогшил, урсгал засварын зардал	1151,2	1150,8	0,4	99,97
Томилот зочны зардал	252,6	250,1	2,5	99,01
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2271,6	2164,4	107,2	95,28
Бараа үйлчилгээний бусад зардал	3626,6	3295,8	330,8	90,88
Татаас	702,2	702,2	0	100,00
Урсгал шилжүүлэг	20886,5	20390,7	495,8	98,21
Хөрөнгийн зардал	4214,2	3824,4	389,8	90,75
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	2456,8	1011,5	1445,3	41,17
Нийт дүн	94091.2	91270.7	2820,6	97,20

Төсвийн гүйцэтгэл 97,2% байгаа ба төсвийн хэлбэлзэлд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зөрүү нөлөөлж байна.

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төсвийн зарлагыг хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллаар нь батлан хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрөөр нь харуулбал:

Код	Хөтөлбөр	/сая,төг/		
		Төлөв	Гүйцэт	%
70105	ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	1548,1	1538,0	99,4
70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	9230,1	9179,5	99,4
70204	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	48,6	48,6	100
70426	Төрийн өмчийн эрхийн хэрэгжилт	166,9	166,9	100
70503	Орон нутгийн зорилтот Хөрөнгө оруулалт	3711,8	3380,6	91,1
70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	65,4	64,3	98,2
70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	711,8	671,2	94,3
71101	Авто зам	522,9	458,3	87,6
71402	Биологийн төрөл зүйлийг хамгаалах	1821,6	1524,1	83,7
71403	Ойжуулалт	89,9	89,9	100
71411	Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	621,1	618,7	99,62
71502	Хот байгуулалт, тохижилт	832,1	830,7	99,8
71504	Газрын зураглал, кадастар	249,8	249,3	99,8
71506	Суурин газрын усан хангам	278,8	278,8	100
71508	Гурамжны гэрэлтүүлэг	32	32	100
71602	Эмнэлэгийн тусламж үйлчилгээ	6275,8	6275	99,9
71701	Биеийн тамир спорт	401,1	399,5	99,6
71702	Соёл урлаг	2520,5	2519,2	99,9
71801	Сургуулийн өмнөх боловсрол	11752,3	11749,8	99,9
71802	Ерөнхий боловсрол	34428,6	34413,4	99,9
71806	Насан туршын болон албан бус боловсрол	333,1	328,5	98,6
71902	Нийгмийн халамж	13703,2	13220,5	96,5
72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2501,8	1033,5	41,3
72207	Хүүхдийн хөгжил хамгаалал	280,3	280,1	99,9
72208	Ахмад настны хөгжил хамгаалал	400,4	400,4	100
72301	Ангилалдаагүй бусад	1563,4	1519,9	97,2
	Нийт дүн	94091.2	91270.7	97,2

Хүснэгтээс харахад дараах хөтөлбөрийн хэрэгжилт хамгийн доогуур хувьтай байна.

Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт - 41,3%
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн хэрэгжилт - 83,7%-ийн биелэлттэй
- Авто зам хөтөлбөрийн хэрэгжилт – 87,6%
- Орон нутгийн хөрөнгө оруулалт хөтөлбөрийн хэрэгжилт – 91%-ийн гүйцэтгэлтэй байна.

Нэмэлт төсвийн талаар: Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсвийн байгууллагуудын нэмэлт төсвийн гүйцэтгэлийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэсэн байна. Аймгийн хэмжээнд нэмэлт төсвийн дансаар нийтдээ 2302,4 сая төгрөгийн орлого орж, 87,9 сая төгрөгийг төвлөрүүлж, зардлын гүйцэтгэл 92,6%-тай байна.

Орон тооны талаар: Тайлант онд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нийт 5308 орон тоо батлагдсанаас 5327 орон тоогоор ажилласан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Нийт дүн	СЯ-ны хянасан	Аймаг баталсан	Гүйцэтгэл	СЯ-харьцуулсан	Аймагтай харьцуулсан
1	Орон тоо	5270	5308	5327	38	19

Тайлант онд батлагдсан орон тоог 19-ээр, Сангийн яамны хянасан орон тоог 38-аар хэтрүүлсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан байгаа болно.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Засаг дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Аймгийн khovsgol.gov.mn өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

2017 оны байдлаар төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 3 удаа, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой мэдээллийг 12 удаа, бусад холбогдох мэдээллийг 10 удаа тус тус хоцроож мэдээлсэн байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 18 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан Цэцэрлэг, Шинэ-идэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Хөвсгөл Эрчим ХХК-ийн санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлтийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас хүргүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчилтэй санал дүгнэлт авсан дээрх төсвийн төвлөрүүлэн захирагч болон Хөвсгөл Эрчим хүч ХХК-ний захирал нарт Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэхь заалтын дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж байна.

2.9.2 Мөнгөн хөрөнгө дансны талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдлийг 5132,3 сая төгрөг, эцсийн үлдэгдлийг 6574,6 сая төгрөгөөр илэрхийлсэн байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгө дансанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Мөнгөн хөрөнгө дансыг бүтцээр нь харуулбал:

МӨНГӨН ХӨРӨНГӨ	/сая.төг/	
	5,132,3	6,574,6
Кассанд байгаа бэлэн мөнгө	10,0	3,5
Төрийн сангийн харилцах	4,797,3	5,773,8
Арилжааны банк дахь харилцах	293,2	771,1
Арилжааны банк дахь харилцах	0.0	26,2
Замд яваа мөнгөн хөрөнгө	31,8	0.0


Мөнгөн хөрөнгө данс нь өмнөх оноос 1442,3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт мөнгөн хөрөнгийн 99,9%-ийг банкинд байгаа бэлэн мөнгө ба төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгө эзэлж байна. Германы Барут Марк хот, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хооронд хамтран ажиллах санамж бичгийг 2011 оны 7 дугаар сард байгуулсан байна. Уг санамж бичгийн хүрээнд “Мөрөн суманд “Сургалтын төв”-ийг байгуулах гэрээ байгуулсан байна.

Гэрээний эхний санхүүжилт 21111,42 евро Хас банкинд байрших дансанд орж ирсэн байна. Гадаад валютын үлдэгдэл 9042,37 евро буюу 26,2 сая төгрөгийн үлдэгдлийг мөнгөн хөрөнгө дансанд тайлагнасан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус данстай холбоотой 106,9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж, 96,7 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулсан ба мөнгөн хөрөнгийн дансанд залруулагдаагүй алдаа үлдээгүй болно.

Аудитын хугацаанд мөнгөн хөрөнгийн дансанд 10,3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, цаашид дахин давтахгүй байх зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой алдаа, зөрчлийг байгууллагаар нь харвал:



Нийт алдаа, зөрчлийн 94%-ийг орон нутгийн байгууллагууд, 1,4%-ийг тусгай шилжүүлгийн байгууллагууд, 4,7 хувийг орон нутгийн өмчит ХХК эзэлж байна.

2.9.3 Авлага дансны талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд авлага дансны эхний үлдэгдлийг 7645,0 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдлийг 6831,8 сая төгрөгөөр тайлагнасан байна. Авлага данс өмнөх оноос 813,2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд 50,4 сая төгрөгийн устгал, төсвийн ерөнхийлөн захирагчийн шатанд 33,6 сая төгрөгийн устгах бичилт авлага данстай холбоотой хийгдсэн байна. Устгах бичилтийн 97,2% нь татаас санхүүжилтийн авлагатай холбоотой бичилт байна.

Авлага дансыг бүтэцээр нь харуулбал:
/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Ажиллагчидтай холбогдсон авлага	22,8	30,1
Төлбөртэй үйлчилгээний авлага	24,0	27,3
Татаас санхүүжилтийн авлага	111,1	-
Зээлийн хүүгийн авлага	123,0	170,3
Дансны авлага	307,2	316,8
Татвар, НДШ-ийн авлага	7,20	4,8
Байгууллагаас авах авлага	1477,7	1223,5
Хувь хүмүүсээс авах авлага	95,1	85,8
Зээлийн авлага	5476,8	4973,1
Нийт дүн	7645,0	6831,9
Урьдчилгаа	0,9	6,2



Дээрх хүснэгтээс харахад авлага дансны нийт үлдэгдэлийн 72,7% буюу 4973,1 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл эзэлж байна.

Төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлага данстай холбоотой гарсан алдаа зөрчлийн талаар: Төсвийн шууд захирагч, төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1855,9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүний 1711,5 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна. Энэ нь нийт зөрчлийн 96,8%-ийг эзэлж байгаа ба сум хөгжүүлэх сангаас олгож байгаа зээл нь төсвийн хөрөнгийг эрсдэлд оруулж байгааг харуулж байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 1.7 –д заасан “Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд тодорхой тусгана”, энэ журмын 3.5.2-т заасан “Төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах” гэсэн заалтуудын дагуу сумын Засаг дарга хэрэгжүүлээгүй зөрчил илэрч байна.

Аудитаар авлага дансанд илэрсэн 91.3 сая төгрөгийн алдаанаас 77,0 сая төгрөгийг аудитын хугацаанд залруулж, 14.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа үлдсэн байна. Цагааннуур сумын ЗДТГ-ын даргад 5,8 сая төгрөгийн авлагатай холбоотой албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Шийдвэрлэсэн нь: Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл барагдахгүй байгаа, жил бүр нэмэгдэж, төсвийн хөрөнгийг эрсдэлд оруулж байгааг ТЭЗ-ийн анхааралд хандуулж, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.2 заалтыг хэрэгжүүлэн, удирдлагаар ханган ажиллах зөвлөмж өгөв.

2.9.4 Бараа материал дансны талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материал дансны эхний ба эцсийн үлдэгдлийг дараах байдлаар тайлагнасан байна.

Үүнд: /сая.төг/

Үзүүлэлт	Эхний	Эцсийн	зөрүү
Бараа материал	9035,2	9381,9	-346,6
Нөөцийн бараа	32,0	448,9	-416,9

Бусад эргэлтийн хөрөнгө	180,5	1425,4	-1244,9
-------------------------	-------	--------	---------

Бараа материал данс тайлант онд 346,7 сая төгрөгөөр, нөөцийн бараа 41,7 сая төгрөгөөр, бусад эргэлтийн хөрөнгө 1244,9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж бараа материалын нөөц 1244,9 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материал дансыг бүтцээр нь харуулбал:
/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Тусгай зориулалтын материал	1 000,3	1 117,0
Эм боох материал	243,8	226,9
Дуусаагүй үйлдвэрлэл	10,5	13,7
Бэлэн бүтээгдэхүүн	85,6	109,7
Бичиг хэргийн материал	144,9	145,4
Аж ахуйн материал	2 525,3	2 695,3
Сэлбэг хэрэгсэл	326,0	258,6
Түлш, шатах тослох материал	539,7	455,9
Барилгын засварын материал	184,2	206,9
Хүнсний материал	663,4	529,5
Бусад хангамжийн материал	3 013,8	3 340,1
Мал амьтад	297,8	282,9
Нийт дүн	9 035,2	9 381,9
Нөөцийн бараа	32,0	448,9
Тэжээлийн нөөц	32,0	448,9
Бусад эргэлтийн хөрөнгө	180,5	1 425,4

Хүснэгтээс харахад: Бараа материал дансны үлдэгдлийн 35%-ийг бусад хангамжийн материал, 28,7%-ийг аж ахуйн материал, 11,9%-ийг тусгай зориулалтын материал, 5,6%-ийг хоолны материал, 4,8%-ийг түлш, шатах тослох материал, тус тус эзэлж байна. Улсын нөөцөд нэмэгдсэн малын тэжээл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн дуусаагүй ажлын үлдэгдэл нэмэгдүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материал данстай холбоотой гарсан алдаа зөрчлийн талаар:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материал дансанд нийт 195,5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүний 149,1 сая төгрөг нь санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа, 46,4 сая төгрөг нь хууль, журмын холбогдох заалт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна.

Нийт алдааны 93,1% буюу 138,9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 10,2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа үлдсэн байна. Залруулах боломжгүй алдаа, зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмжийг тухайн шатны төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн болно.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэг: Эгийн ундарга ХХК-аас 2,0 сая төгрөгийн хүүхдийн хоолны материалд Япон улсын олон найрлагат бүтээгдэхүүн нийлүүлсэн зөрчил илэрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хүүхдийн хоолны материалд нийлүүлж байгаа бүтээгдэхүүний чанар стандартад хяналт тавьж, дүнг Төрийн аудитын байгууллагад ирүүлэх зөвлөмжийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж байна.

2.9.5 Үндсэн хөрөнгийн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдлийг 140676,1 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдлийг 152352,7 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийг байгууллагын төрлөөр нь авч үзвэл:

/сая. төг/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Төсөвт байгууллага	116721,6	123880,3	-7158,7
ОНӨҮГ	23954,4	28472,4	-4517,9
Нийт	140676,1	152352,7	-11676,6

Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 11676,6 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Нийт үндсэн хөрөнгийн 81,3% нь төсөвт байгууллагууд дээр, 18,7% нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын

санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгө данстай холбоотой гарсан алдаа зөрчлийн талаар:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгө дансанд нийт 4870,6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүний 4844,1 сая төгрөг нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг орлогод аваагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг алдаатай тооцож тайлагнасан, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа, 26,6 сая төгрөг нь хууль, журмын холбогдох заалт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна.

Аудитын хугацаанд 99,5% буюу 4820,6 сая төгрөгийн алдааг залруулсан байна. Тайланд үндсэн хөрөнгө данстай холбоотой 23,4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа үлдсэн байна. **Үүнд:**

№	Байгууллагын нэр	Дүн /мян.төг/	Зөрчлийн утга
1	Ханх сумын ЗДТГ	20000,0	Үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй Хороо ходонгийн давааны зам засварын ажлыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн зөрчил илэрсэн.
2	Чандмань-өндөр Эрүүл мэндийн төв	3432,1	Сумын ИТХ-н тогтоол, шийдвэргүйгээр үндсэн хөрөнгийг устгаж данс бүртгэлээс хассан зөрчил илэрсэн.
3	Нийт дүн	23432,1	

Баянзүрх сумын Эрүүл мэндийн төвд 2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 1 мотоцикль, бусад эх үүсвэрээр 2 мотоцикль нийлүүлэгдсэн байна. Үүнийг хөрөнгө оруулалтын аудитаар хянахад 2 мотоциклийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй зөрчил илэрсэн болно.

Шийдвэрлэсэн нь: Бусад эх үүсвэрээр нийлүүлэгдсэн 2 мотоциклийг 2018 оны эхний хагас жилд нягтлан бодох бүртгэлд бүртгэх зөвлөмжийг хүргүүлж байна.

2.9.6 Урт болон богино хугацаат өр төлбөрийн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдлийг 2880,8 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдлийг 2232,8 сая төгрөгөөр, урт хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдлийг 3217,3 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдлийг 3154,1 сая төгрөгөөр тус тус тайлагнасан байна. **Үүнд:**

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Ажилчидтай холбогдсон өглөг	49,5	30,3	19,2
2	Бараа үйлчилгээний зардлын өглөг	405,3	56,2	49,1
3	Татаас, санхүүжилт, шилжүүлэгийн өглөг		3,1	- 3,1
4	Зээлийн хүүгийн өглөг	475,9	475,9	-
5	Байгууллагад төлөх өглөг	1 557,0	1 329,4	227,6

6	Хувь хүмүүст төлөх өглөг	36,9	9,7	27,2
7	Татварын өглөг	178,1	194,2	- 16,1
8	НДШ-ийн өглөг	137,2	80,1	57,1
9	Дансны өглөг	28,1	40,8	- 12,8
10	Урьдчилж орсон орлого	13,0	13,1	- 0,1
11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2 881,0	2 232,8	648,2
12	Урт хугацаат өр төлбөр	3217,3	3154,1	63,2

Нийт богино хугацаат өр төлбөр тайлант онд 648,2 сая төгрөгөөр буурсан байна. Урт хугацаат өр төлбөр тайлант онд 63,2 сая төгрөгөөр буурсан байна. Урт хугацаат өр төлбөрийн 124,2 сая төгрөг нь хөдөөгийн ядуурлыг бууруулах төслийн үлдэгдэл, 3029,8 сая төгрөг нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл байна.

Төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар өр төлбөр данстай холбоотой гарсан алдаа зөрчлийн талаар:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөр данстай холбоотой нийт 190,4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 167,8 сая төгрөгийн алдаа, 22,5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитаар илэрсэн алдааг бүрэн залруулж, гарсан зөрчилтэй холбоотой зөвлөмжийг шат шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

2.9.7 Эзэмшигчийн өмчийн талаар

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 156603,9 сая төгрөг, эцсийн үлдэгдлийг 171634,9 сая төгрөгөөр илэрхийлж тайлагнасан байна. Тайлант онд 15031,0 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Аудитаар тус данстай холбоотой алдаа, зөрчил илэрээгүй болно.

2.9.8 Хуримтлагдсан үр дүнгийн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Хуримтлагдсан үр дүнгийн оны эхний үлдэгдэл 34859,0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 45135,1 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайлант онд 10276,1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Аудитаар тус данстай холбоотой алдаа, зөрчил илэрээгүй болно.


2.9.9 Дахин үнэлгээний нөөцийн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дахин үнэлгээний нөөц нь үндсэн хөрөнгө данснаас хассантай холбоотойгоор 152,3 сая төгрөгөөр буурч, 2017 оны эцэст 17823,4 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

2.9.10 Орлого дансны талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийт орлогыг 110273,2 сая төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд 107770,6 сая төгрөгөөр орлогыг тайлагнасан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар орлого данстай холбоотой нийт 1144,7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс нягтлан бодох бүртгэлийн бичилт, орлого дансны хүлээн зөвшөөрөлттэй холбоотой 1025,5 сая төгрөгийн алдаа, 119,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Нийт алдаанаас аудитын хугацаанд 1019,8 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 5,7 сая төгрөгийн алдаа тайланд үлдсэн байна.



Аудитаар илэрсэн алдааны 95,6%-ийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, нийт илэрсэн зөрчлийн 87,1%-ийг төсвийн төвлөрүүлэн захирагчид эзэлж байна. Эндээс харахад орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй, сумдууд батлагдсан орлогын төлөвлөгөөг хангалтгүй биелүүлж байгааг харуулж байна.

2.9.11 Зардал дансны талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийт зардал 97587,5 сая төгрөг, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 100403,2 сая төгрөгөөр тус тус тайлагнасан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар зардал данстай холбоотой илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардал данстай холбоотой нийт 838,9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 170,7 сая төгрөгийн алдаа, хууль, журам, зааврыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 668,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитаар нийт 167,2 сая төгрөгийн алдааг залруулж, 3,5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа үлдсэн байна.

2.9.12 Хөрөнгө оруулалтын талаар

2017 онд хөрөнгө оруулалтаар нийт 286 төсөл арга хэмжээнд 9331,3 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 8870,2 сая төгрөг гарсан байна. Үүнд:

№	Эх үүсвэр	Хөтөлбөр, арга хэмжээний тоо	2017 оны			Бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгэгдсэн
			Батлагдсан	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	32	1389,6	1358,9	30,7	634,6
2	Орон нутгийн хөгжлийн сан	202	3382,8	3089,1	293,7	551,5
3	Замын сан	18	522,9	458,3	64,6	0
4	Улсын төсвийн хөрөнгө оруулалт /эрх шилжиж ирсэн/	28	3928,4	3884,6	43,8	0
5	Засаг дарга	6	107,6	79,3	28,3	215,4
Дүн		286	9331,3	8870,2	461,1	1401,5

Хүснэгтээс харахад: Хөрөнгө оруулалт үлдэгдэл 461,1 сая төгрөгөөс ОНХС-ийн үлдэгдэл 293,7 сая төгрөг тухайн дансандаа үлдэгдэлтэй байгаа ба 167,4 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Хөрөнгө оруулалтын дуусаагүй 1401,5 сая төгрөгийн ажлуудыг санхүүгийн тайланд бусад эргэлтийн хөрөнгө хэсэгт тайлагнасан байна.

2.9.13 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар орон нутгийн урсгал болон хөрөнгийн зардлаар худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалтыг батлуулсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нь зөвхөн орон нутгийн урсгал болон хөрөнгийн зардлаар худалдан авах 21294,3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг оруулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг орхисон байна.

Худалдан авах ажиллагааны тайлангаас харахад 2017 онд 44068,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1986 төсөл арга хэмжээг худалдан авч, гүйцэтгэл 99,9%-тай байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
Тоо	Дүн /сая/	Тоо	Дүн /сая/
288	21294,3	1986	44068,0

Төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү 22773,7 сая төгрөг байгаа нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн, аймгийн 2 удаагийн тодотголоор нэмж батлагдсан, гадаадын зээл тусламжийн хөрөнгө, төр хувийн хэвшлийн түншлэлээр зохион байгуулсан төсөл арга хэмжээгээр зөрүүтэй байна.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Тосонцэнгэл сумын харьяат МУ-ын арслан Ц.Содномдоржид 30,0 сая төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн, Мөнх Хада ХХК-аас 147,0 сая төгрөгөөр Ландкрузер 200 автомашин худалдан авсан зэрэг нь Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай" Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 4 дэхь заалт, МУ-ын Их Хурлын 47 дугаар тогтоолын "в"-ийн 6 дугаар зүйлд "төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн анхаарал татахуйц үйл ажиллагаа болсон байна.
2. Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 20 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан"-ийн журмын 1.2 заалтын дагуу орон нутгийн тусгай сангийн хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд болон сонгосон арилжааны банкинд тусгай дансанд байршуулан гүйцэтгэлд хяналт тавьж байх, 20 дугаар тогтоолын 2.1.2-д заасан заалтаар тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон зээлийн хүүгийн орлогоор эх үүсвэрийг бүрдүүлэх арга хэмжээ авах ба сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлд хүү тооцож, сангийн эх үүсвэрт ашиглаж байх" гэсэн өмнөх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
3. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Зүүн мөрөн " хорооллын / Бугат/ 35 квт-ын цахилгаан хангамжийн шугам сүлжээ, дэд станцын барилга угсралтын 3579,3 мянган сая төгрөгийн өртөгтэй ажлыг улсын комисс 2015 оны 12 дугаар сарын 04-нд хүлээн авч УКА-34/2015 дугаар актаар хүлээлгэн өгсөн байна. Тус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байсныг аудитаар орлогод тусгуулсан болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД


1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг 2018 онд хийх "Орон нутгийн

- хөрөнгө оруулалт” гүйцэтгэлийн аудит болон “ОНХС-ийн зарцуулалт” нийцлийн аудитаар дахин хянах
2. УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 2018 онд гүйцэтгэх нийцлийн аудитаар нарийвчлан авч үзэх
 3. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан”-д 2018 оны 9 дүгээр сард хийгдэх “Орон нутгийн хөрөнгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар тус тус нарийвчлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хамрагдсан байгууллагуудаас “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг 3 байгууллага, “Сөрөг” санал дүгнэлтийг 1 байгууллага, “Дүгнэлт өгөхөөс татгалзах” санал дүгнэлтийг 2 байгууллагад тус тус хүргүүлсэн ба бусад байгууллагуудад “Зөрчилгүй” санал дүгнэлтийг хүргүүлсэн болно. /Хавсралт-2/


Зөрчилтэй санал дүгнэлт авсан байгууллагын тоог өмнөх онтой харьцуулахад:



2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудаас “хязгаарлалттай” санал дүгнэлтийг 2 байгууллага авч байсан бол 2017 оны байдлаар зөрчилтэй санал дүгнэлтийг 8 төсөв захирагч авсан байна. Зөрчилтэй санал дүгнэлт авсан байгууллагууд нь тусгай шилжүүлэгийн болон орон нутгийн өмчит байгууллагууд байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан шат шатны төсвийн захирагчдын санхүүгийн тайланд нийт 8819,1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5919,3 сая төгрөгийн алдаа, хууль, журмын холбогдох заалтуудыг дагаж мөрдөөгүйтэй холбоотой 2899,7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Аудитаар 5862,1 сая төгрөгийн алдааг залруулж, 57,2 сая төгрөгийн алдаа, 2899,7 сая төгрөгийн зөрчил залруулагдаагүй байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт залруулагдаагүй 999,1 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил, 1957,8 сая төгрөгийн материаллаг бус зөрчил үлдэж байна. **/Хавсралт -01/**

Дээрх алдаа зөрчлийг багцлан үзвэл:



Нийт алдааны:

- Хөвсгөл Эрчим ХХК, Хоймор нутгийн чулуу ХХК, Хөвсгөл ус суваг ХХК -81%,
- Орон нутгийн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагууд - 6,3%
- Сумдын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн хяналтад байдаг төсвийн шууд захирагч нарын санхүүгийн тайланд 12,7%-ийг эзэлж байна.

Нийт зөрчлийн:

- Сумдын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн хяналтад байдаг төсвийн шууд захирагчид – 80,2%-ийг
- Орон нутгийн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагууд – 4,8%-ийг
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд – 115,1%-ийг гарсан зөрчил эзэлж байна.

Аудитаар нийт илэрсэн зөрчилд 5,7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 85,8 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажилласан байна.

Аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулбал 783,7 сая төгрөгөөр өссөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	2016 он	2017 он	+,-
Алдаа	5220,8	5919,3	698,5
Зөрчил	2984,9	2899,7	85,2
Нийт	8205,7	8819,0	783,7

Өмнөх оноос алдаа 698,5 сая төгрөгөөр, зөрчил 85,2 сая төгрөгөөр өссөн байгаа нь хууль журмын хэрэгжилт хангалтгүй, аудитын зөвлөмжийг бүрэн

хэрэгжүүлээгүй, шат шатны төсөв захирагч нарын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт хангалтгүй, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудын хяналт хангалтгүй зэргээс алдаа зөрчил нэмэгдсэн байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ТАЛААР

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 9 зөвлөмжийг хүргүүлсэн ба биелэлт 78,4 % байгаа ба 1 зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй талаар тайлбар ирүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг аймгийн СТСХ-ийн даргын 2018 оны 8/711 дугаар албан бичгээр Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

2.14 . МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг сонгов.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 110273,2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 2205,5 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, гүйцэтгэлийн шатанд баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

